

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ
ХЭРЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД ЧОЙБАЛСАН ХОТЫН
ЗАХИРАГЧ О.ПУРЭВ-ОЧИР

НИЙЛҮҮЛЭГЧ
"БАНДО ЭЛЕКТРОНИКС" ХХК-ИЙН
ЗАХИРАЛ ELECTRONICS
Д.ОЮУНБАДРАХ

ДОРНОД АЙМАГ, ХЭРЛЭН СУМ "ТӨРИЙН ТУСГАЙ ЧИГ ҮҮРЭГ БҮХИЙ
БАЙГУУЛЛАГЫН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ /ЦАГДААГИЙН ГАЗАР/"
БАРАА НИЙЛҮҮЛЭХ АЖЛЫН ГЭРЭЭ

Дугаар: ДОХЭОНТ/23-35

Чойбалсан хот

2023.03.13

Нэг талаас Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газар (цаашид "захиалагч" гэх), нөгөө талаас "Бандо электроникс" ХХК (цаашид "нийлүүлэгч" гэх) нар дараах зүйлийг харилцан тохиролцож 2023 оны 03 дугаар сарын 13-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид "гэрээ" гэх) байгуулав.

Нэг. Ерөнхий нөхцөл

1.1. Монгол Улсын Захиргааны ерөнхий болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж сууринуулах, бараа материал нийлүүлэхтэй холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

1.2. Захиалагч нь "Төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагын тоног төхөөрөмж /Цагдаагийн газар/" (цаашид "бараа" гэх) **47,390,000.0 /дөчин долоон сая гурван зуун өрэн мянган/** төгрөг (цаашид "гэрээний үнэ" гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу барааны нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

1.3. Гэрээний нийт дүн: **47,390,000.0 /дөчин долоон сая гурван зуун өрэн мянган/** төгрөг.

Үнээс

сумын Орон нутгийн төсвөөс 2023 онд: **47,390,000.0 /дөчин долоон сая гурван зуун өрэн мянган/**

1.4. Барааг нийлүүлэх гэрээний хугацаа:

1.4.1. Бараа нийлүүлж эхлэх хугацаа: **2023 оны 03-р сарын 15-ны өдөр**

1.4.2. Бараа нийлүүлж дуусах хугацаа: **2023 оны 05-р сарын 15-ны өдөр**

Хоёр. Захиалагчийн эрх үүрэг

2.1. Захиалагч нь бараа нийлүүлэхээс өмнө барааны тоо хэмжээ, техникийн шаардлагатай танилцан, бусад баримт бичгийг бүрдүүлэн нийлүүлэгчид хүлээлгэн өгнө.

2.2. Захиалагч нь “Төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагын тоног төхөөрөмж /Цагдаагийн газар/” бараа нийлүүлэх явцад техникийн үзүүлэлт бүрээр чанар болон техникийн хяналтыг байнга тавьж ажиллана.

2.3. Нийлүүлэгч нь санхүүжилтээр олгогдсон хөрөнгийг өөр зориулалтаар ашиглах, дур мэдэн тоо ширхэгийг өөрчлөн нийлүүлэх, гэрээний нөхцөлд захиалагч санхүүжилтийг зогсоох, нийлүүлэгчээс татгалзаж гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах хүртэл арга хэмжээг авч, учирсан хохирлыг төлүүлэх эрх эдэлнэ.

2.4. Захиалагчаас үл хамаарах шалтгаанаар бараа материал нийлүүлэх гэрээт хугацаандaa багтаж хүлээлгэн өгөөгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд үнийн дүнгийн 0.05 хувиар алданги ноогдуулна. Алдангийн нийт дүн 5.0 хувь байна.

2.5. Захиалагч нь барааг хүлээлгэн өгсөнөөс хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид санхүүжилтийг олгоно.

Гурав. Нийлүүлэгчийн эрх үүрэг

3.1. Гэрээнд заасан хугацаанд багтаж батлагдсан зураг төсөв, ажлын тоо хэмжээг зөрчсөн нөхцөлд зөрчлийг тухай бүрт нь арилгаж, буруу, дутуу нийлүүлсэн барааг өөрийн хөрөнгөөр нөхөн нийлүүлж, барааг ашиглагчид хүлээлгэн өгөх техникийн комисс ажилласны дараа акт үйлдэн холбогдох баримт материалын хамт захиалагчид хүргүүлэн гэрээнд заасны дагуу санхүүжилтийг авах эрхтэй.

3.2. Нийлүүлэгч нь “Төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагын тоног төхөөрөмж /Цагдаагийн газар/” барааг захиалагчид шалгуулан, акт үйлдэн фото зураг болон гүйцэтгэлийн зургаар баталгаажуулж гүйцэтгэлд хавсаргах үүрэгтэй.

Дөрөв. Бусад

4.1. Гэрээ нь Засаг дарга эцэслэн баталгаажуулснаар хүчин төгөлдөр болох ба бараа нийлүүлэх зөвшөөрөл олгосон өдрөөс хугацааг тооцно.


4.2. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

4.3. Энэхүү гэрээний нөхцөлд нэмэлт өөрчлөлт оруулах бол талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр өөрчлөлтийг зөвхөн бичгээр хийх ба уг нэмэлт өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг болно.

4.4. Гэрээг хэрэгжүүлэх явцад гарах аливаа маргааныг талууд харилцан зөвшилцэх замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Зөвшилцэж эс чадваас маргааныг шүүхээр шийдвэрлүүлнэ. Зохих тал шүүхэд нэхэмжлэлийг иргэний журмаар гаргана.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Хэрлэн сумын Санхүү албаны дарга
 Г.Алтантоғос

Утас: 99998347

Дэд бүтэц, тээврийн асуудал
хариуцсан мэргэжилтэн

 В.Амартүвшин

Утас: 99061413

Хаяг: Дорнод, Хэрлэн, 6-р баг
Хэрлэн сумын ЗДТГазар

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“Бандо электроникс” ХХК-ийн
 нягтлан бодогч
Ч.Мөнхзул

Хаяг: Улаанбаатар хот, Баянгол
дүүрэг 18 дугаар хороо 43-84
тоот

РД: 5960231

Утас: 98112430, 94089599

Харилцагч банк: “Худалдаа
хөгжлийн” банк
Дансны дугаар: 473012973